

МОНГОЛ, ЭНЭТХЭГИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Энхбаяр¹

Бенгалийн булан, Энэтхэгийн далай, Арабын тэнгис, Гималайн уулсаар хүрээлүүлсэн Энэтхэг улс бол дэлхийн нэн эртний түүх соёлтой орон юм. Энэтхэг нь байгалийн хийгээд оюун санааны их өвтэй, хүн амын тоогоороо дэлхийд тэргүүлдэг, олон янзын хэл соёл, ёс уламжлал, шашин шүтлэгтэй, Энэтхэгийн гэж үлдэх баялаг ихтэй орон. Өнөөдөр даяаршлын үед Энэтхэг улс бүс нутагтаа төдийгүй дэлхийд хүчирхэгжин хөгжиж байгаа Азийн нэгэн том гүрэн болоод байна.

Монгол, Энэтхэг хоёр улс нь өнө эртний түүхэн уламжлалт соёлын харилцаатай улсууд билээ. Энэхүү харилцаа сүүлийн жилүүдэд өргөжин бүхий л салбарыг хамарч, батжин бэхжиж байгаа нь хоёр орны харилцаа түншлэлийн хэмжээнд хүрснийг илтгэж байгаа билээ. Бид энэхүү өгүүлэлдээ хоёр улсын шинжлэх ухааны хамтын ажиллагааны асуудлыг товч тоймлон авч үзэх зорилго тавьж байна.

Монгол улсын нутаг дэвсгэр дээр оршин байсан эртний овог аймгууд болон эзэнт гүрний үед ч ийм маягийн айлчлал, хамтын ажиллагаа зохих хэмжээнд байсан нь эртний соёлт Энэтхэгийн эрдэмтэн мэргэд, бичгийн хүмүүсийн нөлөө, шинжлэх ухааны мэдлэгийн үр хөврөлөөс монгол бичгийн хүмүүсд түгээн дэлгэрүүлж байсан нь ойлгомжтой.

XX зуун бол Монгол-Энэтхэг хоорондын ердийн уламжлалт соёлын харилцааг шинэ шатанд гаргаж хамрах хүрээг өргөтгөсөн үе юм. 1947 онд Шинэ Дели хотноо болсон Азийн орнуудын хэлхээ холбооны анхдугаар бага хуралд монголын төлөөлөгчид оролцож Энэтхэгийн анхны Ерөнхий сайд Ж.Нерутай уулзсан нь шинэ харилцааны эхлэл байв. Удалгүй 1955 онд Бээжин хотноо суугаа Монгол, Энэтхэгийн элчин сайд нарын хэмжээнд хэлэлцээ явагдаж БНМАУ-БНЭУ 1955 оны 12-р сарын 25-нд БНМАУ, БНЭУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосноор Энэтхэг улс социалист бус орнуудаас Монгол улстай бүрэн хэмжээний дипломат харилцаа тогтоосон анхны орон болсон юм.

¹ МУИС-ийн багш, доктор (Ph.D), профессор

Шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа түүхэн уламжлалтай бөгөөд нэн эрт үеэс лам хуврага, ном бичгийн хүмүүс харилцан айлчилж бие биедээ нөлөөлж байсан нь нэгэнтээ түүхийн баримт сэлтээр нотлогдсон байдаг. Тухайлбал, МЭӨ 552 онд Хойд Энэтхэгийн Удайна мужийн лам Нарендраяаш нөхдийн хамт Нирун улсаар аялсан тухай нэрт эрдэмтэн, түүхч Г.Сүхбаатар өгүүлсэн байна.²

Монгол, Энэтхэгийн шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааг 1950-иад оны сүүлээс эхэлсэн гэж үзэж болно. Энэтхэгийн эрдэмтэн, нийгэм-улс төрийн нэрт зүтгэлтэн, улс төрийн Жамсангх намын анхны Ерөнхийлөгч асан, Энэтхэгийн өнөөгийн төр засгийн эрхэнд байгаа Бхаратия Жаната Намыг үндэслэгч профессор Рагу Вира 1955 онд Монголд хүрэлцэн ирж байсан билээ. Рагу Вира өөрийн үндэслэн байгуулсан Соёлын Олон Улсын Академид Азийн олон орноос Энэтхэгийн соёл, шашин, утга зохиолын өв уламжлалын асар их хэрэглэгдэхүүн, ном зохиолыг цуглуулсны дотор Монгол, Орос, Хятад зэрэг улсуудаас цуглуулсан цуглуулга нь томоохон байрыг эзэлдэг. Рагу Вира өөрийн хүү, одоо түүний Академийг үргэлжлүүлэн авч яваа профессор Локеш Чандрагийн хамт Энэтхэгт Монгол судлалыг анх үүсгэх, ялангуяа Энэтхэг, Монголын соёл, шашин, утга зохиолын холбогдол бүхий ховор нандин сурвалж бичиг, ном зохиолыг судлан хэвлэн нийтэлж олны хүртээл болгоход асар их зүйлийг хийсэн нь баримтаар нотлогдож буй билээ. Энэхүү ажлыг нь үнэлэн түүнийг БНМАУ-ын засгийн газраас “Найрамдал” медалиар шагнажээ.

Энд зөвхөн Монгол “Ганжуур”-ын 108 ботийг шинээр хэвлэн гаргасныг нь дурдахад л хангалттай юм. Монголын тал ч уг Академитай хамтран ажиллах талаар багагүй зүйл хийсэн билээ. Монгол Улс энэхүү Академид Монгол “Ганжуур”-ын бүрэн цуглуулгын хувь, мөн “Данжуур”-ын бүрэн цуглуулгын гэрэл зургийг бэлэглэсэн байна³. Академич Б.Ринчен агсан энэхүү Академитай амжилттай хамтран ажиллаж байсан бөгөөд “Данжуур”-ын эхний хэдэн ботийг хэвлүүлсэн болно. Рагу Вира профессор анх 1959 онд Улаанбаатарт болсон Олон Улсын Монгол хэл бичгийн эрдэмтдийн Анхдугаар их хуралд оролцон “Монголын агуу их утга зохиолыг дэлхий дахинд танилцуулья” хэмээх илтгэл тавьж олны анхаарлыг татаж байжээ.

1961 онд хоёр орны хооронд соёл, шинжлэх ухааны хамтын

2 Г.Сүхбаатар. Монголын Нирун улс (330-555), III боть, УБ, 1992, 133-р тал

3 О.Nyamdavaa. Mongolia-Indian relations 2003, New Delhi, p 122

ажиллагааны хэлэлцээр байгуулж, соёл шинжлэх ухааны харилцааг хөгжүүлэхийг бүх талаар дэмжих болсноор Монгол-Энэтхэгийн соёлын хэлхээ холбоо шинэ шатанд гарч хөгжих өргөн боломж бүрдсэн байна. Энэхүү хэлэлцээрийг 1978 онд шинэчлэн энэ хүрээнд эрдэмтэн судлаач багш оюутан солилцох болсон нь чухамхүү тус тусын оронд Монгол болон Энэтхэг судлалыг хөгжүүлэхийн эхлэл болсон байна⁴

Монгол, Энэтхэгийн шинжлэх ухааны, тэр дундаа хэл, түүх, нийгмийн ухааны салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хоёр орны эрдэмтдийн дөрвөн удаагийн симпозиумыг Улаанбаатар, Шинэ Дели, хотноо тус тус ээлжлэн зохион байгуулж, хэлэлцүүлсэн илтгэлүүдийг хэвлүүлж нийтийн хүртээл болгосон нь зөвхөн Энэтхэг төдийгүй, хилийн чанадад Монгол судлалыг сурталчлан таниулсан чухал ач холбогдолтой үйл явдал болжээ. Үүнд: 1986 онд Монгол-Энэтхэгийн эрдэмтдийн анхдугаар уулзалт Жавахарлал Неругийн их сургууль дээр болсон явдал хоёр улсын эрдэмтдийн нягт хамтын ажиллагааны нэг тодорхой хэлбэр болсон юм. Энэхүү уулзалтын үеэр зохиогдсон бага хурлын илтгэлүүдийг тусгай ном болон 1988 онд Делид хэвлэгдэв.⁵ 1988 онд удаах уулзалт Улаанбаатар хотноо болж эмхэтгэл нь 1989 онд Улаанбаатар хотноо, 1991 онд Шинэ Дели хотноо тус тус хэвлэгджээ⁶. Монгол хэлээрх эмхтгэлийг академич Ш.Бира редакторлан хэвлүүлж нийтийн хүртээл болгожээ. 1991 онд Монгол-Энэтхэгийн эрдэмтдийн гуравдугаар уулзалт Шинэ Дели хотноо Жавахарлал Неругийн Их Сургуулийн Олон улс судлалын сургууль дээр болсон бөгөөд илтгэлүүд нь 1992 онд Дели хотноо эрдэм шинжилгээний өгүүллийн эмхтгэл болон хэвлэгдсэн байна.⁷ 1995 онд Монгол, Энэтхэгийн эрдэмтдийн дөрөвдүгээр уулзалт Шинэ Делид болж мөн хэрэглэгдэхүүн нь 1997 онд хэвлэгдэн олны хүртээл болов.⁸

Жавахарлал Неругийн их сургууль болон Олон улсын Монгол Судлалын Холбоо хамтран зохион байгуулсан эрдэм шинжилгээний

4 Б.Энхбаяр Энэтхэг дэх Монгол судлалын талаар өгүүлэх нь, Олон улсын харилцаа сэтгүүл, 2005 УБ №2 43 тал

5 *Perspectives on Mongolia*, ред. R.C.Sharma, Seema publications, 1988, New Delhi

6 Монгол ба Энэтхэг. Редактор Ш.Бира. УБ., 1989, India and Mongolia. Experiences and Interactions, ред. R.C.Sharma, Sh. Bira. Scholars' Publishing Forum, New Delhi, 1991.

7 *Mongolia: Culture, Economy and Politics /Indo-Mongolian Assessment*. Editors: R.C.Sharma, K.Warikoo, M.Haidar; 'Sh.Bira, New Delhi, 1992/.

8 /Mongolia. Tryst with Change and Development. Editor: R.C.Sharma. Vision and Venture. Patiala, New Delhi, 1997).

хурал Олон улсын Монголч эрдэмтдийн анхдугаар бага хурал нэртэй явагдсан нь уулзалтын хэлбэр, агуулгыг өргөтгөх зорилготой байсан бөгөөд тус хуралд Монгол, Энэтхэгээс гадна Орос, Герман, Английн эрдэмтэд оролцжээ. Бага хурлын үйл ажиллагаа Энэтхэгийн олон нийтийн анхаарлыг багагүй татаж байсан бөгөөд нээлтийн ажиллагаанд нь Энэтхэг улсын Гадаад хэргийн Төрийн сайд эрхэмсэг ноён Ф.Л.Бхартия, Энэтхэг улсын төрийн сайд байсан, улс төр, нийгмийн нэрт зүтгэлтэн доктор Каран Сингх зэрэг төр, олон нийтийн албаны хүмүүс оролцсон байна.

Гадаад хэргийн сайд Бхартия Бага хурлыг нээж хэлсэн үгэндээ Энэтхэг, Монгол хоёр нийтлэг уламжлал, соёл, нийгмийн эртний их харилцаатай учир бие биедээ их зүйлийг санал болгож чадах бөгөөд дэлхийн асуудлаарх тэдний нийтлэг үзэл бодол нь хоёр оронд орчин цагийн ардчилсан улсыг байгуулахад тус болох учиртайг онцлон тэмдэглээд энэ бүхэнд монголч эрдэмтэд өөрсдийн судалгаагаар хувь нэмрээ оруулж чадна гэдэгт итгэж байгаагаа илэрхийлжээ. Доктор Сингх: Орос, Хятад газар зүйн хувьд Монголын хөршүүд мөн бол **”Энэтхэг нь Монголын оюун санааны хөрш мөн”** хэмээн онцлон тэмдэглэсэн нь санамсаргүй зүйл биш бөгөөд Энэтхэгийн нэртэй эрдэмтэн, төр нийгмийн зүтгэлтэн хүн Монгол улсыг ийнхүү тодорхойлсноороо онцлог юм.

Бага хурлын талаар Энэтхэгийн төвийн нэгэн хэвлэл болох “The Hindustan times” сонинд нэрт сэтгүүлч Латик Падгаонкар “Утга зохиолын 600 жилийн холбоог мөшгих нь” хэмээх өгүүлэл нийтлүүлж байв¹⁰. Сэтгүүлч бичихдээ Бага хурлын зорилго бол зөвхөн ганц шинжлэх ухааны арга хэмжээ төдий бус, мөн монгол судлалын талаар дотоодынхоо эрдэмтдийн сонирхлыг татахад оршиж байсныг тэмдэглээд, “Бид хамтран ажиллахыг хүсэж байна. Энэтхэг, Монголын эрдэмтэд Банинын /Банини/ зохиолыг хамтран судлавал хичнээн сайхан байх билээ” хэмээсэн нь Энэтхэгт монгол судлалыг хөгжүүлэхэд томоохон алхам болсныг харуулж байна.

Энэхүү оюун санааны хөршийн харилцаа холбоо бол тэр болгон бусад улс орны хооронд байдаггүй бөгөөд манай хоёр хувьд олон зуун жилийн өмнөөс бий болж, үүссэн түүхэн аргамжааны алтан зангилаа

9 R.C.Sharma Perspectives on Mongolia New Delhi 1988

10 Ш.Бира.Монгол Энэтхэгийн уламжлалт харилцааны үлэмж өвийг судлах асуудалд, Энэтхэг-Монголын харилцааны эх сурвалж(ЭШХИлтгэлийн эмхтгэл),2005 УБ,20 тал Tracing a 600-year-old Literary Link”. The Hindustan times. New Delhi. February 27, 1995/.

юм.¹¹

1990-ээд онд Монголын улс төрийн амьдрал болон гадаад харилцааны чиг шугамд өөрчлөлт гарч шинэ нөхцөл байдал бий болсон билээ. 1992 онд БНЭУ-ын дэд ерөнхийлөгч Доктор Шанкар Даяал Шарма Монгол улсад албан ёсны айлчлал хийсэн нь Монгол улсад гарсан өөрчлөлтийн дараахь Энэтхэгийн албан ёсны анхны томоохон айлчлал байсан. Монгол улсын Үндэсний хөгжлийн сайд Ж.Батсуурь тэргүүтэй төлөөлөгчид Энэтхэг улсад айлчилж хэлэлцээ хийснээр хоёр орны хооронд шинжлэх ухаан-техник, мэдээлэл харилцааны технологийн хамтын ажиллагааны эхлэл тавигдаж хоёр орны харилцааны хувьд шинэ салбар нээгдсэн юм.

Энэ дашрамд тэмдэглэхэд хоёр талын харилцааны хүрээнд ярьж тохиролцсон олон зүйл бодит амьдрал дээр хэрэгжихгүй цаг хугацаа алддаг нь судалгааны явцад анзаарагдсан бөгөөд үүний нэг жишээ нь МУИС-ийн НШУС-ийн Буддын судлалын төвийг өргөтгөж Самгарди судлал, Энэтхэг судлалын ангийг нээхээр хоёр засгийн газар шийдвэрлэсэн ч өнөөг хүртэл хэрэгжээгүй байна.

2008 оны 9-р сард Энэтхэг судлалын төв “Монгол-Энэтхэгийн харилцаа, хамтын ажиллагаа ба даяаршил” сэдэвт олон улсын бага хурлыг Улаанбаатар хотноо зохион байгуулсан бөгөөд хуралд Энэтхэг, Орос, Хятад, Япон зэрэг олон улсын эрдэмтэн судлаачид оролцож илтгэл хэлэлцүүлсэн байна. Мөн Гадаад хэргийн сайд С.Оюун Энэтхэгийн элчин сайд Ёгишвар Варма болон Энэтхэг судлаачид оролцож хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны тухайн үеийн байдал болон хэтийн төлөвийн талаар санал бодлоо солилцсон¹² нь харилцаа хамтын ажиллагааны ахиц дэвшлийг харуулсан чухал үйл явдал болсон юм.

Монгол-Энэтхэгийн хооронд дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлыг Монгол-Энэтхэгийн Найрамдлын Нийгэмлэг, Энэтхэгийн Соёлын Төв, Монгол Улсын Их сургуулийн Санскрит, Буддын судлалын Тэнхим хамтран 2010 оны 12 сарын 13-нд зохион явуулсан¹³. Энэ хуралд БНЭУ-аас Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Сатбир Сингх оролцож, хурлын үйл ажиллагаанд амжилт хүсэхийн хамт хоёр орны харилцаа улс төр, шашин соёл, оюун санааны хувьд иж бүрэн цэцэглэн хөгжиж ирсэн ч эдийн засгийн орон зай хоосон байгааг онцлоод

11 *O.Nyamdavaa Mongolia-India relations 2007UB. p 231*

12 *O.Nyamdavaa.Indian studies in Mongolia,2005 № 4*

13 *www.num.edu.mn*

цаашид хамтын ажиллагааг цоо шинэ шатанд гаргахыг уриалсан. Мөн тэрбээр тэрбум гаруй хүн амтай Энэтхэгийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бизнес, боловсрол, мэдээллийн технологи, анагаах ухааны салбарын ололт амжилтаас хуваалцан, олон талт нөхөрлөлөө улам бүр бэхжүүлнэ гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлсэн байна.

Энэтхэг дэх Монгол судлал

Монгол-Энэтхэгийн соёл, боловсролын харилцаа, хамтын ажиллагааны хөгжилд Монгол дахь Энэтхэг судлал, Энэтхэг дэх Монгол судлал онцгой үүрэг гүйцэтгэсээр ирсэн. Энэтхэгийн Монгол судлалыг их сургууль, судалгааны байгууллагын хэмжээнд болон хувь судлаач, эрдэмтдийн хүрээнд гэж хоёр хувааж үзэж болно.

Энэтхэг дэх Монгол судлалын эхийг тавихад өмнө дурдсан Энэтхэгийн эрдэмтэн Раху Вира Монгол улсад хэд хэдэн удаа айлчилж үүнээс үндэслэн Энэтхэгийн соёлын олон улсын академи дээр Монголын судалгаа хийж эхэлсэн явдал чухал үүрэг гүйцэтгэсэн. Энэхүү академиас эрхлэн Монгол-Санскрит болон Санскрит-Монгол толь бичиг, Аржи Буржи болон Бигармижид хааны намтар зэргийг хэвлүүлэн гаргажээ.¹⁴Тус академи Монгол судлал болон Монголын бурхны шашинтай холбоотой ном бүтээл хэвлүүлж олны хүртээл болгосны зэрэгцээ их эрдэмтэн Б.Ринчен, Ц. Дамдинсүрэн, Ш.Бира нарын зэрэг Монголын нэртэй эрдэмтэд, судлаачидтай холбоотой ажилладаг байжээ.

Энэтхэгийн өнө эртний түүхтэй хотын нэгэн Варанасын их сургууль нь Монгол судлалын секцийг байгуулсан анхны институтийн нэг бөгөөд Өвөр Монголоос Галсан Лхүндэв хэмээх багш монгол хэл зааж байсан төдийгүй гарын авлага маягаар монгол хэлний жижиг толь бичиг гаргаж байжээ. Тэр секц хориод жил сургалт явуулаад багш болон шаардагдах сургалтын материалгүйн улмаас хаагдсан¹⁵ байна.

Мөн Энэтхэгийн баруун Бенгаль мужийн Шантиникитан хотын Висва Бхаратын их сургуульд монгол судлалаар ажилладаг багш нар цөөнгүй байсан байна. Хятад хэлний профессор Вэй Вэй Сэн хэмээх багш “Монголын нууц товчоо”-ны монгол хувилбар дээр үндэслэн “Монгол гүрний нууц товчоон” гэсэн ном бичиж хэвлүүлсэн байна.¹⁶

14 *O.Nyamdavaa.Mongoli-India relations 2003,New Delhi,p 122*

15 *Б.Энхбаяр.Энэтхэг дэх Монгол судлалын талаар өгүүлэх нь, Олон улсын харилцаа сэтгүүл 2005 УБ 44 тал*

16 *В.Enkhbayar,A few words on Mongolian studies in India, Indian studies in Mongolia2008 №4 УБ,p 74*

Энэ сургуульд Өвөр Монгол гаралтай Энэтхэгийн иргэн Лама Чинпа хэмээх Монголд элэгтэй нэгэн эрдэмтэн ажиллаж байсан. Тэрээр Монгол-Англи ярианы жижиг толь бичиг зохион хэвлүүлж байжээ. Лама Чимпа монгол хэл сурах эрмэлзлэлтэй оюутан нилээд байсан ч ном сурах бичиг болон шаардлагатай хангамж нөхцөл тааруу байсныг дурджээ.¹⁷

Энэтхэг улсын хэмжээнд Монгол судлалыг хөгжүүлж байгаа хамгийн том төв бол Жавхарлал Неругийн Их Сургууль юм. Энд засгийн газрын хооронд байгуулагдсан албан ёсны гэрээ хэлэлцээрийн үндсэн дээр монгол судлалын хичээлийг заах болсон.

Тус сургуулийн хэл соёлын сургууль дээр 1973 онд Монгол хэлний салбар байгуулагдсан бөгөөд анхны зочин багшаар хэл шинжлэлийн ухааны доктор /Sc.D/академич Төмөртоогоо ажиллаж байжээ. Тэр цагаас хойш арав гаруй багш монгол хэл заасан байна. Энэ салбар тус сургуулийн Япон болон Зүүн Хойд Ази судлалын төвд харьяалагддаг. Монгол хэлний сургалт хариуцдаг тус төв нь энэ сургалтыг тасалдуулахгүй явуулах талаар ихээхэн анхаарал тавьж Энэтхэгт суугаа Монголын элчин сайдын яаманд байнга хандаж байдаг.

1970-аад оны эхээр Шинэ Дели хотноо Дэлхийн самгард судлаачдын их хуралд Монголын нэрт эрдэмтэн Б.Ренчин оролцож Монголын уламжлалт үлгэр домогт Энэтхэгийн туульс болон бусад зохиол бүтээлийн өнгө аяс, дүр төрх хэрхэн хадгалагдан үлдсэн тухай илтгэл тавьжээ. Илтгэлээ маш өвөрмөцөөр тавьсан нь төлөөлөгчдийн анхаарлыг татаж байлаа. Тэрээр жижигхэн дуу хураагчинд бичсэн Монгол ардын үлгэр, туульс, уртын дууны хэсгээс сонсгон түүнийгээ тайлбарлан Монгол Энэтхэгийн оюун ухааны уламжлалын хэлхээ холбоо хир гүнзгий хадгалагдан үлдсэнийг тайлбарласан байна¹⁸. Энэ нь Энэтхэгийн эрдэмтэд Монголыг сонирхох, түүхэн харилцаа хэлхээ холбоог судлахад ихээхэн нөлөө үзүүлсэн алхмуудын нэг болсон билээ.

1989 онд Ерөнхий сайд Ж.Батмөнх тэргүүтэй төлөөлөгчид Энэтхэг улсад хийсэн айлчлалын үеэр Ж.Неругийн их сургуулийн Олон Улс Судлалын Сургууль дээр Монгол судлалын салбар байгуулах шийдвэр гарч 1990-д оны эхнээс монгол судлалын багш нар ажиллах болжээ. Энэтхэгийн ерөнхийлөгч асан Р.Венкатраман 17 Б.Энхбаяр. Энэтхэг дэх Монгол судлалын талаар өгүүлэх нь, Олон улсын харилцаа сэтгүүл 2005 УБ 44 тал

18 Д.Чулуундорж. Монгол-Энэтхэгийн дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойд Энэтхэгийн ЭСЯ 2005 УБ, 59 тал

“Манай Жавхарлал Неругийн их сургууль дээр монгол судлалын салбар байгуулах шийдвэр гарч байгааг мэдэгдэхэд таатай байна. Энэ нь манай хоёр оронд Монголын баялаг өв соёл, түүний цаашид үргэлжилж буй олон талт дэвшлийг судлахад маш том боломж олгоно гэдэгт эргэлзэхгүй байна” гэжээ.

Монгол судлалын салбар нь Неругийн их сургуулийн Олон улс судлалын сургуулийн Зүүн Өмнөд, Төв Ази болон Номхон далайн бүс нутаг судлалын төвд харьяалагддаг бөгөөд дундаа завсарлагатайгаар гурван монгол багш зочин профессороор ажилласны сүүлийнх нь миний бие билээ. Монгол зочин багш нар орчин үеийн Монголын улс төр, эдийн засаг, нийгмийн асуудлаар магистраас дээш түвшний оюутнуудад лекц уншихаас гадна Монгол судлалаар сэдэв сонгосон оюутнуудын дипломын ажлыг удирдаж байлаа. Неругийн их сургуульд Монгол судлалын салбар нээсэн нь Энэтхэгийн Монгол судлалын хувьд чухал ач холбогдолтой явдал болсон бөгөөд тэр цагаас хойш энэ сургууль монгол судлалын талаар судалгаа хийдэг тэргүүлэх цөөхөн газрын нэг болсон юм.

Баруун Бенгаль мужийн төв Кольката /Калькутта/ хотод Монгол судлалаар нилээд дорвитой ажилладаг “Азиатик” хэмээх нийгэмлэг байдаг. Уг нийгэмлэгт элчин сайд асан Б.Дашцэрэн жил гаруй Монголын түүх, хоёр орны соёлын харилцаа эртний хэлхээ холбооны талаар англиар лекц уншиж тэнд байсан Ерөнхий консул болон гадаадынхны дунд нэрд гарч, улмаар тэд Дашцэрэн гуайн лекцэнд ирж суудаг байсан¹⁹

Дээрх эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулиас гадна Монгол судлалыг сонирхон судлаж судалгаа шинжилгээ явуулж Энэтхэг оронд энэ ажлыг сурталчилахад хөдөлмөр оюунаа зориулсан, зориулж байгаа Энэтхэгийн олон судлаачид байна.

Энэтхэгчүүд эзэн Чингисийн нэгтгэн байгуулсан Их монгол улсын эртний түүхийг сайн мэддэг. Үүнд Энэтхэгийн анхны ерөнхий сайд Ж.Неру “Ертөнцийн түүхийг сөхөн үзвэл” хэмээх алдарт бүтээлдээ Монголын тухай бичсэн зүйлс, Энэтхэгийн нийгмийн нэрт зүтгэлтэн, уран зураач Н.К.Рерихийн Монгол улсад жуулчилж байсан үеийн уран зургийн гайхамшигт бүтээлүүд нөлөөлсөн. Энэтхэгийн монголч эрдэмтдийн нэг нь Ж.Неругийн нэрэмжит их сургуулийн Олон улс судлалын сургуулийн Төв Ази судлалын тэнхмийн эрхлэгч асан доктор К.Варику юм. Түүний монгол судлалд оруулсан хувь нэмрийг өндрөөр үнэлж Монгол улс “Найрамдал” медалиар шагнажээ.

19 О.Нямдаваа. Монгол-Энэтхэг өнө эртний өнөөгийн түншүүд 2010 УБ, 20 тал

Профессор Варикугийн шавь доктор Ш.Сони Монгол-Орос, Монгол-Хятадын харилцаагаар нэгэн сэдэвт зохиол бичиж нийтлүүлсэн байна. Тус сургуульд олон жил ажиллаад гавьяаныхаа амралтанд гарсан доктор Р.С.Шарма Энэтхэг-Монголын харилцаа хамтын ажиллагаагаар олон семинар, симпозиум зохиож эрдэмтдийн илтгэл, өгүүллийг дөрвөн боть ном болгон хэвлүүлжээ. Энэтхэг Монголын найрамдлын нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн дарга Олон улсын Монгол судлалын холбооны гишүүн байсан тэрээр одоо өндөр насны тэтгэвэртээ сууж байна. Мөн сургуулийн профессор С.С.Деора нь Монголд маш элэгтэй нэгэн юм. Тэрээр өөрийн нэгэн шавийг “Ази дахь гео-стратегийн өөрчлөгдөж буй дүр зураг Монголын жишээн дээр” гэсэн сэдвээр докторын ажил хийлгэжээ.

Монгол улсын өнөөгийн улс төр, эдийн засаг болон хоёр орны харилцааны талаар санал онол дэвшүүлж үнэлэлт дүгнэлттэй өгүүлэл бичиж өнөөгийн энэтхэгчүүдийн мэлмийг мялаадаг хүн бол доктор. П. Стовдан юм. Мөн монголын эртний хаад ноёдын түүх, үйл ажиллагааны талаар перс хэлээр бичсэн зүйлийг судалдаг хүн бол Доктор Мансура Хайдер юм. Түүнчлэн Монгол гаралтай Лама Чимпа буюу Жамбаа нь Шантиникетанд төвд хэлний багшаар олон жил ажиллахдаа Монгол-Англи толь хэвлүүлэхийн зэрэгцээ Монгол Энэтхэгийн харилцаа, Монголын ардын эмнэлэг, хэл утга зохиолын талаар олон өгүүлэл бичжээ.

Төв Ази судлал түүн дотор монгол судлалаар ажилладаг томоохон эрдэмтэн профессор Рам Рахул монгол судлалын салбарыг нээсэн анхдагчдын нэг бөгөөд Монголыг Төв Азийн бүс нутгийн хүрээнд судлаж “Хятад-ЗХУ-ын хоорондох Монгол улс”, “Афганистан, Монгол ба ЗХУ” зэрэг нэгэн сэдэвт бүтээлүүд хэвлүүлсэн монгол судлаач юм²⁰. Эхний бүтээлдээ Монголыг Орос, Хятад хоёр их гүрний дунд байрлах стратеги талаас нь бүхэлд нь судалсан бөгөөд уламжлалт эх сурвалж ашиглаад зогсохгүй Монгол улсад ирж өөрийн биеэр хийсэн судалгаан дээрээ үндэслэн номоо бичсэнээрээ Энэтхэгийн бусад Монгол судлаачдаас давуу талтай. Эдгээр хүмүүстэй манай эрдэмтэд хамтран ажиллаж хоёр орны харилцаа хамтын ажиллагааны төлөө нэгэн үйлсэд хөтлөгдвөл үр дүн нь улам их байх нь ойлгомжтой.

1995 онд Дели хотноо Монголч эрдэмтдийн олон улсын анхдугаар бага хурал болсон нь Энэтхэгийн Монгол судлалын түүхэнд чухал үйл явдал болсон бөгөөд энэ нь анх удаа Монголоос гадна өөр улсад

20 Б.Энхбаяр Энэтхэг дэх Монгол судлалын талаар өгүүлэх нь, Олон улсын харилцаа сэтгүүл 2005 УБ 46-47 тал

болж олон орны эрдэмтдийг оролцуулснаараа онцлог болсон юм. Мөн Энэтхэг эрдэмтдийг Монгол судлал руу хандуулахад чухал хувь нэмэр болсон байна.

ОУМС-ын Холбоо ч дэлхийн олон орны олон зуун эрдэмтэдтэй харилцаж, Холбооноос зохиодог уламжлалт монголч эрдэмтдийн их хуралд монгол хэл, уран зохиол, түүх, соёл, шашин, улс төр, гадаад харилцаа зэрэг өргөн хүрээтэй сэдвээр судалгаа явуулдаг монголч эрдэмтэд оролцдогийн дотор энэтхэгийн монголч эрдэмтэд хувь нэмрээ оруулсаар ирсэн байна. Мөн "Монгол, Энэтхэгийн нийгмийн өөрчлөлт, хөгжил, Азийн хэлхээ холбоо" сэдвээр Монгол Энэтхэгийн симпозиумыг Дели хотноо, "Үе улиран уламжлагдсан Монгол Энэтхэгийн хэлхээ холбоо" сэдвээр Алигардын Их сургуульд семинар, Монголын нууц товчооны 750 жилийн ойд зориулсан семинарыг Дели хотноо тус тус зохион байгуулжээ.

Үүний зэрэгцээ Монгол улсад Энэтхэг улсаас суух элчин сайд нар болон улс төр, нийгмийн зүтгэлтнүүд Дэлхийн банк, Дэлхийн эрүүл мэндийг хамгаалах байгууллага болон бусад нийгэм, эдийн засаг, соёл боловсролын шугамаар Монголд амьдарч ажиллаж байсан хүмүүсийн дурсамж дурдатгал Энэтхэг дэх Монгол судлалын хөгжилд хувь нэмэр оруулсаар ирснийг дурдах нь зүйтэй. Хэдий тийм боловч Энэтхэг дэх монгол судлал нь эртнээс нааш харилцаатай явж ирсэн "оюун санааны" хөршүүдийн хувьд бусад улс дахь монгол судлалтай харьцуулахад туйлын хангалтгүй байгааг тэмдэглэмээр байна.

Монгол дахь Энэтхэг судлал

Монголын нэртэй эрдэмтэд асан Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен, Ш.Лувсанвандан, Б.Ширэндэв, Ш.Нацагдорж нар Энэтхэгт удаа дараа айлчилж Монгол, Энэтхэгийн билиг ухаан, оюун санааны уламжлалт харилцааг сэргээх үйлсэд жинтэй хувь нэмэр оруулж байсан. Тэд Энэтхэг орноор зочилсон тухайгаа хуучилж, Монгол-Энэтхэгийн уламжлалт харилцаа, шашин, номын их өв, уламжлалын талаар олон сайхан санал, зөвлөгөө гаргаж байсан болно. Нэрт эрдэмтэн Бямбын Ринчен 1957 онд БНЭУ-д айлчлан "Өмнө этгээдэд зорчсон тэмдэглэл" гэдгээ гаргаж байсан²¹. 1963 онд Шинэ Делид болсон Дорно дахины судлаачдын их хуралд академич Ш.Бира оролцож "Дандины зохист аялгууны толийн монгол тайлбарууд" сэдвээр илтгэл хэлэлцүүлэхэд

²¹ Ш.Бира. Монгол Энэтхэгийн уламжлалт харилцааны үлэмж өвийг судлах асуудалд, Монгол-Энэтхэгийн эрт эдүгээгийн харилцааны эх сурвалж (ЭШХИлтгэлийн эмхтгэл), 2005 УБ, 16-р тал

Энэтхэгийн эрдэмтэд ихээхэн сонирхож байжээ. Дандины “Зохист аялгууны толийг” судлах ажлыг цаашид өрнүүлэх талаар ихээхэн анхаарч, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд багагүй ажлыг зохион явуулсан нь Монгол-Энэтхэгийн уран зохиолын харилцаа холбоог анхлан судлахад зохих үр дүнгээ өгсөн бөгөөд гадаад, дотоодын олон эрдэмтдийн анхаардыг татаж байсан.

1976 онд Цэндийн Дамдинсүрэн Энэтхэг улсад зохиогдсон “Рамаяана” зохиолын олон улсын бага хуралд оролцож тэрхүү түүхэн зохиол Монгол орноо хэрхэн тархсан тухай илтгэл тавьж, хоёр орны утга зохиолын хэлхээ холбоог баталгаажуулахад хувь нэмрээ оруулсан байна. Түүнчлэн Монгол, Энэтхэгийн эртний хэлхээ холбоо, ялангуяа уран зохиолын харилцан нэвтэрсэн байдал, монголчууд түүнийг хэрхэн орчуулж, ашиглаж ирсэн түүхийг академич доктор Ш.Бира гуай шиг судалсан хүн одоохондоо байхгүй байна гэж үзэж болохоор. Түүний судалгааны онцлог нь Монгол судлалыг Төвд, Энэтхэг судлал болон Төв Азийн соёл иргэншлийн судалгаатай нягт холбон өргөн далайц хүрээтэй судалсанд оршино. Ш.Бирагийн “Монгол, Энэтхэгийн түүх соёлын харилцаа”, “Энэтхэг, Монголын түүх бичлэгийн харилцан холбогдох нь”, Монгол судлал, Энэтхэг судлал хоёр бол дорно дахины судлалын төрөл салбар ухаан болох нь”, “Энэтхэгчүүдийн тухай монголчуудын төсөөлөл” зэрэг цуврал бүтээл, Монгол, Энэтхэгийн эрдэмтдийн хамтын бүтээлүүд англи хэлээр Шинэ Делид хэвлэгдэн гарсан. Мөн Доктор Лувсанвандан, Элчин сайд Б. Жаргалсайхан нар Бурхан багшийн мэлмий гийсний 2500 жилийн ойд зориулсан болон Энх тайвны олон улсын бага хуралд оролцсон бөгөөд хоёр орны эртний уламжлалт хэлхээ холбоо харилцааг хөгжүүлэхэд их үүрэг гүйцэтгэсэн билээ.

Монголын олон эрдэмтэн, дипломатчид Энэтхэгийн алдартай зохиол бүтээлээс эх хэлнээ орчуулж монгол түмэндээ таниулж байгаа нь ихээхэн гавьяатай үйлс мөн. Тэдний дотор доктор Л.Хүрэлбаатар, гүүш Ж.Гэндэндарам, О.Сүхбаатар зэрэг олон эрдэмтэн зүй ёсоор орно. Мөн Энэтхэг улсад олон жил элчин сайдаар ажилласан О.Нямдаваа “Монголчууд ба Энэтхэгийн монгол удмын хүмүүсийн ижил төсөөтэй зүйлс”, “Монгол, Энэтхэг оюун санааны хөрш”, “Монгол, Энэтхэгийн харилцаа” сэдвээр нэгэн сэдэвт зохиол болон судалгааны хялбаршуулсан олон арван өгүүлэл бичиж монгол, англи хэлээр хэвлүүлэн дотоод, гадаадын олон уншигчдын хүртээл болгоод байна.

Профессор Н.Алтанцэцэг Дэли их сургуульд зочин судлаачаар

ажиллаж хийсэн судалгаан дээрээ тулгуурлан Монгол-Энэтхэгийн харилцаа, Энэтхэг-Хятадын харилцаа, Энэтхэгийн гадаад бодлогын чиглэлээр судалгаа явуулах боллоо.

Дүгнэн үзэхэд, Монгол дахь Энэтхэг судлал нь ихэвчлэн хэл, соёл, бурханы шашин болон уран зохиолын чиглэлээр хийгдэж ирсэн бөгөөд Энэтхэг орон судлал, Энэтхэгийн түүхийн судалгаа үндсэндээ хийгдээгүй нь энэхүү судалгааны явцад ажиглагдлаа.

Эртний баялаг түүх, соёл иргэншилтэй, Азид хүчээ авч буй, шинжлэх ухааны ололт амжилтыг нь дэлхий дахин хүлээн зөвшөөрдөг энэ том орныг судалдаг эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургууль Монгол улсын хэмжээнд өнөөг хүртэл байхгүй байгаа нь нэн харамсалтай.

Монгол, Энэтхэг хоёр улс эрт үеэс эхлэлтэй уламжлалт харилцаа холбоотой ч орчин үеийн Энэтхэгийн эрдэмтэд Монголыг тэр бүр их сонирхдоггүй, мэддэггүй бөгөөд Монголын эрдэмтэн судлаачид ч Энэтхэг судлалыг хөгжүүлэх тал дээр дорвитой анхаарал хандуулж арга хэмжээ авахгүй, алдаг оног хамтарсан хурал зохиох төдийхнөөр хязгаарлаж байгаа нь бодитой юм.

Монгол-Энэтхэгийн уламжлалт соёлын харилцааг улируулан судлахад шаардлагатай арвин баялаг эх сурвалж, материал хоёр улсын номын сан хөмрөгт аль алинд нь хангалттай байгаа бөгөөд энэ судалгааг хоёр улсын залуу судлаач эрдэмтэд зохих түвшинд эхлэн явуулах цаг нь болжээ.

Дүгнэлт

Монгол-Энэтхэгийн эртний соёлын хэлхээ холбоонд үндэслэсэн харилцаа нь цаашлаад боловсрол, шинжлэх ухааны салбараар хүрээгээ тэлж эдүгээ олон талт хамтын ажиллагааны бүхий л салбарыг хамарч байна. 1961 онд хоёр орны соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулж, соёлын бүтээлүүдийг солилцох замаар хоёр орны хооронд соёл, шинжлэх ухааны харилцааг хөгжүүлэхийг бүх талаар дэмжих болсноор Монгол-Энэтхэгийн шинжлэх ухааны хамтын ажиллагаа шинэ шатанд гарч хөгжих өргөн боломж бүрдсэн юм.

Монгол-Энэтхэгийн шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааны хөгжилд Монгол дахь Энэтхэг судлал, Энэтхэг дэх Монгол судлал онцгой үүрэг гүйцэтгэдэг. Хоёр орны судлал зохих түвшинд хөгжиж байгаа хэдий ч бусад оронтой харьцуулахад хангалттай биш байна. Эртний шашин болоод соёлын салбарын

харилцааны чиглэлээр судалгаа явуулах эх сурвалж, баримт материалууд хангалттай байгаа ч судалгаа зохих түвшинд хийгдэхгүй байна. Хоёр улсын орчин үеийн харилцаа бүхий л салбарт хөгжиж байгаа нь харилцааны нэгдсэн судалгаа бий болгох шаардлагатайг харуулж байна. Судалгааг зөвхөн шашин, соёлоор хязгаарлахгүй, шинжлэх ухааны бүхий л салбарт өргөн хүрээтэй судалгаа явуулах цаг нь нэгэнт болжээ гэж үзэж байна.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. Монгол улсын гадаад бодлогын хөх ном, ГХЯ, 2006 он
2. “Орчин үеийн олон улсын харилцааны чиг хандлага ба Монгол улс”, МУИС, ОУХС, Улаанбаатар, 2011 он
3. Ж.Неру Ертөнцийн түүхийг сөхөн үзвэл, боть, Улаанбаатар, 1986
4. Энэтхэг судлал сэтгүүл 2007 он, №1
5. Энэтхэг судлал сэтгүүл 2008 он, №4
6. Б.Энхбаяр Энэтхэг дэх Монгол судлал-Олон улсын харилцаа сэтгүүл 2005 он №2
7. Indian studies 2005 № 4
8. Indian studies 2010 №7
9. Mongolia: Culture, Economy and Politics, India-Mongolia assessment. Editors: R.C.Sharma, Sh.Bira, K.Warikoo AND M.Haider, New Delhi. 2000
10. O.Nyamdavaa Mongolia-India relations, New Delhi 2003
11. O.Nyamdavaa. Mongolia and India: Spiritual Neighbours. Himala Publishers, New Delhi 2000
12. Perspectives on Mongolia. Edited by R.C.Sharma. Seema publications. New Delhi, 1988,
13. The Cultural Exchange Programme, New Delhi 2000
14. Enkhbayar B A few words on Mongolian studies in India. Journal. Indian Studies. 2008 №4